

БАНКИНД БАЙРШУУЛСАН, ХАДГАЛУУЛСАН МӨНГӨН ХӨРӨНГИЙН ХҮҮГ ЗАРЦУУЛАХ ЖУРАМ¹

НЭГ.Нийтлэг үндэслэл

- 1.1 МУИС-ийн Хууль зүйн сургуулийн дансыг банкинд байрлуулсан, хадгалуулсан мөнгөн хөрөнгийн хүүг /цаашид “хадгаламжийн хүү” гэх/ үр бүтээлтэй, ил тод зарцуулахад энэ журмыг баримтална.
- 1.2 “Хадгаламжийн хүү” нь банкинд байрлуулсан болон өндөр хүүтэй, хугацаатай хадгалуулсан мөнгөн хөрөнгийн хүүгээс бүрэлдэнэ.

ХОЁР. Хадгаламжийн хүүг зарцуулах

- 2.1 Хадгаламжийн хүүг багш, ажилтан, оюутны сургалт, эрдэм шинжилгээний ажлыг дэмжих, тусламж үзүүлэх, урамшуулал олгох, нийгэм соёлын арга хэмжээ, сургууль сурталчлах үйл ажиллагаа санхүүжүүлэх зорилгоор дараах тохиолдлалд зарцуулна. Үүнд: */2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар өөрчлөн найруулав/;*
 - 2.1.1 Багш, эрдэм шинжилгээний ажилтан докторын зэрэг хамгаалахад сарын цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал олгоно;
 - 2.1.2 */2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар хасав/;*
 - 2.1.3 Багш, эрдэм шинжилгээний ажилтан сургуулийг хөгжүүлэх тодорхой санал, санаачилга гаргасан болон идэвхи зүтгэл, үр бүтээлтэй ажилласан нөхцөлд урамшуулах, үйл ажиллагааг дэмжих зорилгоор 500,000 /таван зуун мянга/ хүртэл төгрөгийн дэмжлэг үзүүлэх; */2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар өөрчлөн найруулав/;*
 - 2.1.4 Багш, ажилтны эцэг, эх гэр бүлийн гишүүд нас барсан тохиолдолд 500,000 /таван зуун мянга/ хүртэлх төгрөг, оюутан нас барсан тохиолдолд түүний ар гэрт 200,000 /хоёр зуун мянга/ хүртэлх төгрөгийг буцалтгүй тусламжаар олгоно. */2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар өөрчлөн найруулав/;*
 - 2.1.5 Оюутны соёлын нэгдсэн арга хэмжээг зөвлөх багш нарын саналыг үндэслэн санхүүжүүлэх;
 - 2.1.6 Тухайн хичээлийн жилд аттестатчилалд хамрагдсан багш нар амжилттай дүн үзүүлсэн бол үндсэн цалингийн 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн урамшуулал олгох */2014 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар нэмэлт оруулав/;*
 - 2.1.7 Багш, ажилтан өөрөө буюу түүний гэр бүлийн гишүүд хүндээр өвчилсөн, эсвэл өндөр өртэгтэй эмчилгээ хийлгэхээр болсон тохиолдолд 1,000,000 /нэг сая/ хүртэлх төгрөгийн буцалтгүй мөнгөн тусламж үзүүлэх */2014 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар нэмэлт оруулав/;*

¹ Захиргааны зөвлөлийн 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хурлаар хэлэлцэж батлав.

- 2.1.8 Багш, ажилтан, оюутан ажлын байр, сургалтын орчиндоо тухайн байгууллагын аюулгүй ажиллагааны журам зөрчигдсөний улмаас гэмтэж бэртсэн тэр нь мэргэжлийн байгууллагын дүгнэлтээр тогтоогдсон тохиолдолд 1,000,000 /нэг сая/ хүртэлх төгрөгийн нэг удаагийн мөнгөн тусламжийг үзүүлэх /2014 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар нэмэлт оруулав/.
- 2.1.9 Монгол Улсын Хууль зүйн шинжлэх ухаанд үнэтэй хувь нэмэр оруулсан нэрт эрдэмтдийг алдаршуулахад чиглэгдсэн арга хэмжээг санхүүжүүлэх /2014 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн Захиргааны зөвлөлийн хурлаар нэмэлт оруулав/
- 2.1.10 Багш, ажилтны нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд 500 000 /таван зуун мянга/ хүртэл төгрөгийн тусламж олгох; /2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар нэмэв/;
- 2.1.11 Сургууль сурталчлах үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх (МУИС-ийн ХЗС-ын нэр, тэмдэг бүхий бүтээгдэхүүн г.м) / энэ тохиолдолд бүтээгдэхүүн худалдсан орлогоор эргэн төлөлт хийнэ./; /2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар нэмэв/;
- 2.1.12 Багш, ажилтны баяр ёслол, нийгэм соёлын арга хэмжээг санхүүжүүлэх; /2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн хуралдаанаар нэмэв/;
- 2.2 Хадгаламжийн хүүг багш, ажилтны хүсэлтэд тулгуурлан Захиргааны зөвлөлийн хурлаар хэлэлцэж, шийдвэрлэнэ. /2014 оны 2 дугаар сарын 6-ны өдрийн хуралдаанаар өөрчлөн найруулав./;
- 2.3 Хадгаламжийн хүүгийн нийт дүн зарцуулалтаас хэтрэхээр бол 2.1.1, 2.1.3, 2.1.4-ийн хэмжээг Захиргааны зөвлөл тухай бүр бууруулан олгохоор шийдвэрлэж болно.

ГУРАВ.Хадгаламжийн хүүгийн зарцуулалтыг тайлагнах

- 3.1 Хадгаламжийн хүүгийн хуримтлал, зарцуулалтын тайланг жил бүр Захиргааны зөвлөлд захирал танилцуулна.
- 3.2 Хадгаламжийн хүүгийн зарцуулалтыг сургуулийн санхүүгийн тайланд бие даасан хэсэг болгон жил бүр оруулна.